Syndicated articles from

FINANCIAL TIMES

© The Financial Times Limited [2015]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Энэтхэгийн төв банкийг тойрсон шүүмжлэл

Мөнгөн тэмдэгтийн гүйлгээнээс хасах шийдвэрийн дараа төв банкны бие даасан байдал хаачив гэх хүн олширлоо. > 10

АНУ-ын компаниудын болгоомжлол

Хятадад ажилладаг АНУ-ын компаниуд Трампад хандаж, худалдааны бодлогоо зөөлрүүлэхийг уриалах бодолтой. > 10

ISIS-ийн дайчид Мосулаас зугтаж байна

Иракийн цэргийн хүчин Мосул хотоос ISIS-ийн дайчдыг шахан гаргаж байгааг албаныхан мэдээлэв. > 10

Сүйрлийн уршигт тахалтай тэмцэх эвсэл

Клайв Куксон, Тим Брэдшоу

Сүйрлийн уршигт тахлын вирусээс хамгаалах шинэ вакцин бүтээх ажилд олон тэрбум ам.доллар зарцуулж чадах дэлхийн эвсэл албан ёсоор үүслээ. Эдүгээ шинэ вакцин бүтээхэд шаардагдаж буй 10 жилийн хугацааг 12 сар хүрэхгүй болтол богиносгож чадна хэмээн уг эвслийг өөрийн сангаар дамжуулан ивээн тэтгэгч гол хүмүүсийн нэг Билл Гэйтс найдаж байна. “Жил хүрэхгүй хугацаанд бүтээж дөнгөхгүй аваас бидэнд өөрсдөд маань гутрам хэрэг болно” хэмээн ноён Гэйтс Давост хуралдаж буй Дэлхийн эдийн засгийн чуулганы үеэр Financial Times-д тайлбарлав.

Тахлаас сэргийлэх инновацийн эвслийг (CEPI - The Coalition for Epidemic Preparedness Innovations) Давосын чуулганы үеэр 460 сая ам.долларын эхний хөрөнгө оруулалттайгаар байгуулжээ. Уг хөрөнгийг ХБНГУ, Япон, Норвегийн Засгийн газар, дэлхийн эрүүлийг хамгаалах гол хоёр хандивын байгууллага - Wellcome Trust, Bill and Melinda Gates Foundation гаргах юм.

Цаашид АНУ, Их Британи, Энэтхэг зэрэг хандивлагч нэмэгдсэнээр ирэх таван жилд нийт хөрөнгө нэг тэрбум ам.долларт хүрнэ хэмээн үүсгэн байгуулагчид нь тооцоолжээ. Вакцин үйлдвэрлэгчид ч эвсэлд нэгдэх хүсэлтэйгээ илэрхийлээд байна.

Шинэ эвсэл Ойрх дорнодын амьсгалын замын хам шинж буюу MERS, Ласса, Нипах, Эбола, Марбург, Зика гэсэн зургаан ноцтой тахлын вирусын судалгааг эн тэргүүнд сонгожээ. Мөн дэлхий нийтийн эрүүл мэндийг хямрааж болзошгүй аливаа шинэ өвчин үүсгэгчийн эсрэг вакциныг шуурхай бүтээх шинжлэх ухаан, технологийн үндэслэл боловсруулах нь ч уг хөтөлбөрийн гол зорилго.

“Хүн төрөлхтний амьдрал, эрүүл мэнд, хөгжил дэвшлийг тахлаас хамгаалж чадахуйц вакцин бүтээх ажилд бид тун ч бага зүйл хийжээ” хэмээн Wellcome Trust-ийн захирал Жереми Фаррар мэдэгдлээ. “CEPI нь сүүлийн үед дараалан болж өнгөрсөн олон эмгэнэлт явдлаас сургамж авч, тахлын эсрэг шинэ вакцинаар хамгаалалт үүсгэх боломжийг нээж өглөө” хэмээн тэрбээр нэмж өгүүлэв.

Өрнөд Африкт 2014-2015 оны хооронд дэгдэж 11000 хүний амийг авч одсон Эбола тахал нь CEPI-г байгуулах гол шалтгаан болсон юм. Уг тахал тархахаас өмнөхөн зарим их сургууль, компанийн лабораториуд тус тусдаа туршилтын вакцин бүтээж чадсан. Гэвч вакциныг хүмүүст хэрэглэж болохуйц аюулгүйн тест эдүгээ хүртэл бүрэн хийж амжаагүй байна.

Тахлын тархац ноцтойг ухамсарласан ДЭМБ зэрэг олон улсын эрүүлийг хамгаалах байгууллагууд найдвартай гэж үзсэн вакциныг клиник туршилтад оруулах шаардлага тавьж эхлэв. Вакцинуудыг тахлын голомтод турших явцад халдварын тархац аяндаа буурсан ч Гвинейд хэрэглэсэн вакцин бусдаасаа илүү үр дүнтэй нь батлагдсан. Гэвч вакциныг хэрэглээнд нэвтрүүлэхэд хэдэн сарын хугацаа алдсанаас болж олон мянган хүний амь хохирчээ.

“Эболагаас сургамж авч, цаашид хүмүүсийн эрүүл мэндэд тулгарах аюулаас сэргийлэх арга замыг хамтран боловсруулах шаардлагатайг ухамсарласан вакцин үйлдвэрлэгч тэргүүлэх компаниуд, олон улсын эрүүл мэндийн байгууллагууд CEPI-гийн суурийг бүр өнгөрсөн оны Давосын чуулганаар тавьсан” хэмээн GlaxoSmithKline-ийн (GSK) ерөнхий захирал Сэр Эндрю Уитти тайлбарлав.

“Тахал байнга дэгдээд байдаггүй тул зах зээл асуудлыг лав шийдвэрлэхгүй. Шийдвэрлэхээр боллоо ч хүмүүс их мөнгө шаардах аргагүй” хэмээн ноён Гэйтс тайлбарлаж байлаа. Гэхдээ GSK зэрэг вакцин үйлдвэрлэгчдэд CEPI-г дэмжих үйл ажиллагааны болоод санхүүгийн учир шалтгаан бий. “Онцгой нөхцөл үүссэнээс үүдэн вакцин бүтээх салбарт түгшүүрийн харанга дэлдэх нь биднийг гарах гарцгүй байдалд түлхдэг. Өнөөдөр дэлхийн вакцин үйлдвэрлэлийн тогтолцоонд сул зай үлдээгүйг хүмүүс ойлгодоггүй” хэмээн Сэр Эндрю өгүүлсэн юм.

GSK ирээдүйд дэгдэж болзошгүй тахлыг эмчлэх вакциныг орлогын бус үндсэн дээр бүтээхийн тулд Мэрилэнд муж улсын Роквиллд байрладаг судалгааны төвөө CEPI-д ашиглуулах санал тавиад байна. CEPI нь Норвегийн нийслэл Осло хотод байрлана. Тус байгууллага тэмээнээс хүнд халдварладаг, үхлийн аюултай амьсгалын замын өвчин - MERS, мэрэгчээс гаралтай, цус алдуулдаг чичрэг – Ласса, сарьсан багваахайнаас хүнд халддаг, амьсгалын зам, уураг тархийг гэмтээгч – Нипах гэсэн гурван тахлын эсрэг тус бүр хоёр вакцин бүтээх юм. Мөн Зика, Марбург, Эболагийн хэд хэдэн төрлийг анагаах вакцин боловсруулна. FT

Хятадын олборлолт коксжих нүүрсний үнийг унагалаа

Нил Хьюм

Бээжингийн шахалтад хариу болгон Хятадын уурхайнууд олборлолтоо ихэсгэсэн нь 2016 оны шилдэг үзүүлэлттэй таваар коксжих нүүрсний үнийг унагалаа. Өрөндөө баригдсан нүүрсний үйлдвэрлэлийн орлогыг сайжруулахын тулд Хятад улс олборлолтыг нь багасгасны дүнд 2016 онд коксжих нүүрсний үнэ эрс өссөн юм.

Өнгөрсөн оны арванхоёрдугаар сард коксжих нүүрсний үнэ дөрөв дахин өсөж тонн нь 300 ам.долларт хүрчээ. Ийм огцом өсөлт хамгийн сүүлд 2011 онд тохиолдсон түүхтэй. Олборлолтыг багасгасан нь дулааны цахилгаан станцад эрчим хүч гаргахад хэрэглэдэг хүрэн болон чулуун нүүрсний үнийг ч өсгөж, Anglo American, Teck Resources, Glencore зэрэг үйлдвэрлэгчдийн орлогыг ихэсгэв.

Гэвч коксжих нүүрсний үнийн огцом өсөлт ган төмөрлөгч үйлдвэрлэгч компаниудыг түгшүүлж эхэллээ. Бээжингийн бодлого тодорхойлогчид ажлын өдөрт тогтоосон чанд зохицуулалтаа зөөлрүүлж, олон зуун уурхайд өвлийн халаалт дуусах гуравдугаар сарыг дуустал олборлолтоо өсгөх зөвшөөрөл олголоо.

“Уурхайн ажлын өдрийг жилд 276-гаар тогтоосон хязгаарлалтаа Хятадын эрх баригчид 330 болгосон нь олборлолт өсөхөд хүргэв. Хятадын зах зээлд дотоодын коксжих нүүрсний нийлүүлэлт аажим боловч тогтвортой нэмэгдэж байна” хэмээн судалгааны Steel Index компани саяхан нийтэлсэн тайландаа тайлбарлажээ.

БНХАУ-ын Улсын хөгжил, шинэчлэлийн комисс (тайлбар: хуучнаар Улсын төлөвлөгөөний комисс) олборлолтыг өсгөх бодлого хэрэгжүүлж байгаа нь дотоодын уурхайнуудын үйлдвэрлэл сэргэх, Хятад төдийгүй олон улсын хэмжээнд коксжих нүүрсний үнэ буурахад хүргэнэ хэмээн шинжээчид таамаглаж байна. “Дотоодын нийлүүлэлт ихэссээр. Энэ хандлага, ялангуяа дулааны цахилгаан станцын хэрэглээний нүүрсний хувьд илт байгаа” хэмээн CRU консалтингийн группын Стивен Дак өгүүллээ.

Эрэлтийн талаас нь авч үзвэл Хятадын ган төмөрлөг боловсруулах үйлдвэрүүдийн ихэнх нь энэ өвөл дуустал хэрэглэх нөөцөө хэдийнэ базаачихсан. Мягмар гарагт Австралийн дээд зэрэглэлийн коксжих нүүрсний Хятадад хүргэх үнэ тонн нь 175.9 ам.доллар байлаа. Энэ нь он гарснаас хойш үнэ 22 хувиар унасан үзүүлэлт болохыг Steel Index-ийн тайланд тайлбарлажээ. Өнгөрсөн онд тонн нь 110 ам.доллар байсан эрчим хүчний зориулалттай нүүрсийг эдүгээ 82 ам.доллараар арилжиж байна.

Үнэ унасан нь зөвхөн дотоодын зах зээлээс хамаарсан хэрэг бус. Өнгөрсөн арванхоёрдугаар сард Drummond Coal, Warrior Met Coal, Blackhawk зэрэг АНУ-ын олборлогчид Хятад дахь үнийн өсөлтөөс ашиг гаргах зорилгоор экспортоо өсгөснийг ноён Дак дурдлаа. АНУ-д 30 сая тонн орчим коксжих нүүрсний нөөц хуримтлагдсан байж болзошгүй талаар Barclays-аас саяхан нийтэлсэн тайланд анхааруулжээ. Үүний ихэнх нь коксжих нүүрсний дундаж үнэ 2015 онд 105 ам.доллар болтлоо унамагц олборлолтыг нь зогсоосон цагаас хойш хуримтлагдсан нөөц.

Үүний зэрэгцээ 2015 онд тонн нь 100 ам.доллар хүрэхүй хямдарсан Австрали, Канад, Мозамбикийн коксжих нүүрсний олборлолт сэргэсэн нь нийлүүлэлтийн дарамтыг ихэсгэв. Хар салхины улирал Австралийн коксжих нүүрсний үйлдвэрлэлд хал балгүй өнгөрлөө. Үер нийлүүлэлтэд нөлөөлөхөөс болгоомжилсон Glencore, Nippon Steel компани энэ оны эхний улиралд коксжих нүүрсний нэг тонныг 285 ам.доллараар тооцохоор бүр арванхоёрдугаар сард тохиролцсон.

Хятадын эрх баригчид нүүрсний үнийг олборлогчдод ашигтайн зэрэгцээ эрчим хүчний компаниуд, ган төмөрлөгч үйлдвэрлэгчдэд дарамт учруулахгүйгээр тэнцвэр бариулна хэмээн шинжээчид таамаглаж байна. FT

Syndicated articles from

FINANCIAL TIMES

© The Financial Times Limited [2015]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

ВВМ©

Энэтхэгийн төв банкийг тойрсон шүүмжлэл

Дэвид Кеохане, Киран Стейси

Энэтхэгт мөнгөн тэмдэгтийн 86 хувийг гүйлгээнээс хасах шийдвэр гарсны дараа төв банкны бие даасан байдал хаачив гэх хүмүүс олширлоо. Улс орны хамгийн чухал институцийн чадавхид эргэлзсэн, шүүмжилсэн үгс хэвлэл мэдээллээр тарж байна. Нарендра Моди том дэвсгэртийг хасах тухай шийдвэр гаргах үед арваннэгдүгээр сард Энэтхэгийн нөөцийн банкны тэргүүнээр томилогдсон Уржит Пател ажлаа аваад хоёр сар болж байгаа юм.

Мөнгө солих машин хангалттүй, бэлэн мөнгөний хүрэлцээ муу байснаас гэнэтийн шийдвэр улс даяар эмх замбараагүй байдал үүсгэв. Эхлээд төв банкнаас зөвлөмж авч маш нарийн төлөвлөх ёстой байсан арга хэмжээг гэнэт нэвтрүүлсэн нь нөөцийн банкны бие даасан байдлыг хөндлөө гэсэн шүүмжлэл гарч байна. Тус банкны захирагч асан Ив Редди "Төв банкны эдийн засагт гүйцэтгэх үүрэгт аюул учруулж, үндэсний хэмжээнд бэрхшээл үүсгэлээ" гэж дүгнэв.

Мөнгийг гүйлгээнээс хасах шийдвэрт төв банкны зөвшөөрөл шаардлагатай агаад Энэтхэгийн мөнгөний бодлогод ойрын үед гараагүй чухал шийдвэрт төв банкны оролцоо ямар байсныг эргэн нягтлахыг шаардсан дуу хоолой сонсогдож эхлэв. Арван-хоёрдугаар сард төв банкнаас парламентад ирүүлсэн тайланд Засгийн газраас уг асуудлыг авч үзэх зөвлөмж хүлээн авснаас хойш ганц хоногийн дараа уг төлөвлөгөөг дэмжсэн тухай дурджээ. Сөрөг Конгресс намын үед Сангийн сайд байсан Чидамбарам "Захирагч төв банкны эрх мэдэлд халдах боломжийг Засгийн газарт олголоо" хэмээн буруутгасан байна.

Энэтхэгийн нөөцийн банк шаардлагатай доод хэмжээний шинэ дэвсгэртийг хэвлэсэн учир солих арга хэмжээг эхлүүлсэн гэсэн боловч дараа нь улс даяар бэлэн мөнгөний дутагдал үүссэн билээ. Ийнхүү шүүмжлэл нэмэгдэж буй үед Засгийн газраас мэдэгдэл гаргаж, нөөцийн банкыг дэмжихийн сацуу төв банкны эрх мэдэлд халдсан гэж шүүмжлэгсдэд хариу өгчээ. Тухайлбал, Сангийн сайд "Засгийн газар Энэтхэгийн нөөцийн банкны бие даасан, тусгаар байдлыг хүндэтгэж буйгаа хариуцлагатай мэдэгдэж байна" гэсэн юм.

Шийдвэр гаргах үйл явцаас гадна төв банк бодлогыг хэрхэн хэрэгжүүлж буй байдал мөн шүүмжлэлтэй тулгарч, бэлтгэлгүй байсан, шийдвэр гаргасан мөртөө дүрэм журмаа өөрчлөөгүй, урьд үзэгдээгүй эдийн засгийн туршилтын талаар мэдээлэл хангалтгүй байгаа гэх мэт үг яриа гарсан байна. Ноён Чидамбарам "Нөөцийн банк мөнгө солих ажиллагааг чадваргүй, мэргэжлийн бус байдлаар явуулаа" хэмээн шүүмжлэв.

Ноён Пателийг шүүмжлэхдээ түүнийг өмнөх захирагч Рагхурам Ражантай харьцуулж байгаа аж. Ражан тал тохой татдаг байдал, нийгмийн үл хүлцэл зэргийг шүүмжилдэг хүн учир Засгийн газар түүнийг төв банкнаас зайлуулсан гэж шинжээчид үздэг. Лондон дахь GAM фирмийн менежер Пол МкНамара "Буруу ч бай, зөв ч бай, Ражаны үед ийм арга хэмжээ авах боломжгүй байсан. Одоо үүнийг нурлаа гэх нь хэтрүүлсэн хэрэг болно" хэмээв. Хоёр сарын турш мөнгөний дутагдлаас болж, эдийн засаг тасалдаж байхад Пател хоёрхон удаа хэвлэлд ярилцлага өгсөн бөгөөд түүнийг олон нийттэй харилцахаас цааргалж байна гэсэн шүүмжлэл бас дэгдэв.

Гэсэн хэдий ч төв банк зарим хүний эргэлзээнээс санаа авч чадавхаа дээшлүүлэх, инфляцийн зорилтоо шинэчлэн тогтоох зэрэг алхам хийж магадгүй юм. Standard and Poor-ын шинжээч Киран Карри мөнгө солих ажиллагааны талаар "Энэ явдал төв банкны чадавхи, бие даасан байдалд сүүдэр тусгалаа. Гэвч бид уг институцийг маш найдвартай гэж үзсэн хэвээр байна. Мөнгөний бодлого явуулахын хувьд эднийх маш боловсронгуй байгууллага" хэмээн үнэлсэн юм. Legal & General Investment Management компанийн эдийн засагч Эрик Лует гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд энэ бол онц хамаатай асуудал бус гээд "Сардаа нэг удаа ашгийг тооцож олгодог. Иймээс тэд хүүгээ авч байгаа цагт өөр зүйлд нэг их анхаарахгүй" гэв.

FT

АНУ-ын компаниудын болгоомжлол

Люси Хорнби, Шон Доннан

Хятадад хөрөнгө оруулдаг АНУ-ын компаниуд Трампын засаг захиргаанд хандаж, худалдааны асуудлаар бодлогоо зөөлрүүлэхийг уриалах бодолтой байна. Хэрэв шинэ захиргаа импортын тарифыг өсгөх амлалтаа хэрэгжүүлбэл Америкийн компаниуд хариу арга хэмжээнд өртөж болзошгүй байгаа аж. Америкийн худалдааны танхимын Бээжингийн бодлогын хорооны дарга Лестер Росс "Хятад хариу арга хэмжээ авахаар бэлтгэж, алхам хийж, анхааруулж байгаа" гэжээ.

АНУ-ын бизнесийнхэн Бээжинтэй хэлэлцээ хийхэд Вашингтоноос тусламж хүсэж, худалдаа, хөрөнгө оруулалт, оюуны бүтээлийн хамгаалалт зэрэг асуудлаар зовнилоо улам шаргуу илэрхийлэх болсон. Гэвч одоо Трамп Хятадад үйлдвэрлэсэн барааны өндөр тариф тогтоовол ямар үр дагаварт хүрэхийг Хятадын бизнесийнхэн цэгнэж үзэх цаг ирлээ. Хятадаас АНУ-д экспортлодог олон бүтээгдэхүүнийг Америкийн компаниудад буюу тэдний нэрийн өмнөөс үйлдвэрлэсэн байдаг. Эдгээр компани мөн Хятад дахь борлуулалтаас ихээхэн хамааралтай. Иймээс тэд АНУ тарифаа нэмбэл Бээжин хариу арга хэмжээ авна хэмээн болгоомжилж байгаа юм.

АНУ-ын улс дамнасан корпорациуд олон жилийн турш тусламж хүсэж байгааг Хятадын асуудлаар мэргэжилтэн Скот Кеннеди онцлоод "Гэтэл одоо тусламж ирэхээр өөрсдөд нь муу юм болох нь хэмээн түгшиж эхэллээ" гэжээ. AmCham-ын Бээжин дэх салбарын захирал асан бизнесийн зөвлөгч Жеймс МкГрегор "Хятад дахь Америкийн бизнес бүлгийнхэн яг одоо тайван бус байна" хэмээв. Хятадад шахалт үзүүлэх нь сайн хэрэг боловч Твиттерийн мэдэгдэл Хятадтай харилцах ухаалаг арга биш үзэж байна.

AmCham-ын тэргүүн Уильям Зарит "Худалдааны дайн хэн нэгэнд ашиг авчирна гэж бодохгүй байна" гэсэн нь мягмар гарагт Давосын чуулган дээр Хятадын Ерөнхийлөгч Ши Жинпиний хэлсэн үгтэй нийцэж байгаа юм. АНУ-д бизнесийнхэн Трампын засаг захиргааны хувьд "хүлээе, харъя" гэдэг зарчим баримталж, түүний таах аргагүй хэв маягт дасан зохицохыг эрмэлзэж буй бололтой. Тэд Трампын протекционист бодлого Хятадтай худалдааны дайнд хүргэх талаар зовнилоо нууж, татвар, зохицуулалтыг багасгах эерэг амлалтад төвлөрч байгаа аж.

Трампын дайралтын бай болоод буй Boeing компанийн захирал Деннис Муиленбург "Ноён Трамп бизнесийнхнийг захиргаандаа оруулж байгаа нь сайн хэрэг. Үүн дээр бүгд санал нэгтэй байгаа" гэжээ. Сурталчилгаа дуусан хэдий ч Трамп Хятадын талаар үг яриагаа зөөлрүүлсэнгүй. Түүний бүрдүүлж буй худалдааны багт Хятадыг шүүмжлэгчид олон орсон нь Хятадтай худалдааны дайн эхлүүлэхгүй гэсэн найдварт эргэлзээ үүсгэжээ. Шинэ Ерөнхийлөгч Бээжин, Вашингтоны хооронд тохиролцоод удаж буй нэг Хятадын бодлогыг дахин хэлэлцэх боломжтой гэсэн шуугиан тариад байгаа. Тэрбээр Бээжин өөрийн мөнгөн тэмдэгтийн ханш дээр тоглолт хийж байна хэмээн буруутгасан авч Ерөнхийлөгч болсон эхний өдрөө Хятадыг валютын залилагч хэмээн зарлана хэмээн амласнаа хэрэгжүүлэхээс татгалзсан гэнэ.

FT

ВВМ©

ISIS-ийн дайчид Мосулаас зугтаж байна

Эрика Соломон

Иракийн цэргийн хүчин Мосул хотын зүүн дүүргүүдээс ISIS-ийн дайчдыг шахан гаргаж байгааг албаныхан мэдээлэв. Тус улсын Ерөнхий сайд гурван сар үргэлжилсэн довтолгооны дараа ялалт байгуулах нь гарцаагүй гэж мэдэгдсэн юм. Хот руу дайралтыг удирдаж байгаа Иракийн терроризмын эсрэг албаны тэргүүн хэлэхдээ түүний цэргүүд лхагва гарагт Мосулын дундуур урсдаг Тигрис мөрний зүүн эргийн хяналтдаа авснаар төлөвлөгөөний дагуу эзлэх ёстой бүсийг гартаа оруулаа гэж мэдээлжээ. Цэргийн бусад бүлгүүд хотын зүүн хойд дүүрэгт давшилтаа үргэлжлүүлж байгаа аж.

Иракийн хоёр дахь том хотыг хяналтдаа буцаан авах ажиллагаа хэрэгжвэл жихадын бүлэг эндэх хамгийн том түшиц газраа алдах юм. Мосулыг эргүүлэн авах ажиллагаа Багдадын гол зорилт агаад Барак Обамагийн засаг захиргааны гадаад бодлогын чухал хэсэг байсан. ISIS Ирак болон Сирид халифат гэгч улс байгуулах хүрээнд саяхнаас энд хэд хэдэн довтолгоон хийсэн байна. Гэвч тус бүлэг 2014 онд Мосулыг эзэлж, хойд Иракийн нэлээд нутгийг эрхэндээ авч байсан үеийг бодвол одоо хяналтад байсны нутгийнхаа арав хүрэхгүй хувийг гартаа барьж байгаа аж.

Иракийн Ерөнхий сайд Хайдар Абадийн мэдэгдэлд "Манай баатарлаг зэвсэгт хүчний амжилтын үр дүнд Мосулд ялалт улам ойртож, хотыг чөлөөлөх амлалт хэрэгжих дөхлөө. Хотын төв болон зүүн эргийг жихадаас цэвэрлэх төлөвлөгөө үндсэндээ хэрэгжиж дуусла" хэмээн онцолжээ. Мосулын төлөөх тулалдаан өнгөрсөн аравдугаар сард эхэлсэн бөгөөд зүүн бүсийг эзлэн авах нь баруун хэсгийг довтлохоос хавьгүй хялбар байсан гэж ажиглагчид үзэж байна. Хотын нарийн гудамжууд, тэнд суугаа энгийн иргэдэд хохирол учрах тул Иракийн цэргүүд дайралтаа үргэлжлүүлэх нөхцөл хүндэрч байгаа юм. Гудамж руу гүн орчихвол заримдаа хэд талаас галлах аюулд өртдөг гэж цэргийн ярив.

ВВМ©

Иракийн цэргүүд болон АНУ тэргүүтэй эвслийнхэн сүүлийн хэдэн долоо хоногт дараалан дотолгоо хийсний дүнд зарим амжилтад хүрлээ. Тигрис голын дээгүүрх гүүрүүдийг ISIS-т тусламж очихоос сэргийлэн холбоотны онгоцууд бөмбөгдсөн. Түүнчлэн Иракийн цэргүүд тэдэн рүү илгээдэг машинтай бөмбөгийг устгахдаа дадлагажиж байгаа аж. Терроризмын эсрэг хүчний командлагч генерал Талиб Шагхати хотын баруун хэсгийг эзлэхэд хялбар байх болно гэжээ. Гэвч энд хүн ам шигүү, тэдний зарим нь ISIS-ийг дэмждэг тул довтолгоон саатах байх гэж шинжээчид ярьсан билээ.

АНУ-ын албаныхан саяын амжилт нь Мосул хот дотор Иракийн цэргүүдтэй хамт Америкийн хүчнийг байрлуулсантай холбоотой гэж үзэж байгаа аж.

FT